



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ СУРГУУЛЬ



ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА


WORLD AFFAIRS

2012 №1 381 (24)



УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ СУРГУУЛЬ



ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

WORLD AFFAIRS

2012 №1 381 (24)



Улаанбаатар хот

DDC
327'015
O-295

Тус сэтгүүл нь анх 1996 оноос “Алтан аргамж” нэрээр, 2002 оноос “Олон улсын харилцаа” нэрээр гарч байна.

The journal has been published since 1996 as “Altan argamj” and since 2002 as “World Affairs”

Сэтгүүлийн зөвлөл:

Эрхлэгч:

Н.Алтанцэцэг (Проф., Ph.D)

Нарийн бичгийн дарга:

Д.Тунгалаг (Проф., Ph.D)

Гишүүд:

Ж.Баясах (Проф., Sc.D)

Д.Отгончимэг (Проф., Ph.D)

Б.Энхбаяр (Проф., Ph.D)

Д.Цолмон (Проф., Ph.D)

Editorial Board:

Editor in Chief:

N.Altantsetseg (Prof., Ph.D)

Assistant Editor

D. Tungalag (Prof., Ph.D)

Members:

J.Bayasakh (Prof., Sc.D)

D.Otgonchimeg (Prof., Ph.D)

B.Enkhbayar (Prof., Ph.D)

D.Tsolmon (Prof., Ph.D)

Хэвлэлийн эх бэлтгэсэн:

С.Оюунсүрэн (Ph.D)

Publishing design:

S.Oyunsuren (Ph.D)

Сэтгүүлийн хаяг:

МУИС-ийн Олон улсын харилцааны сургууль

Шуудангийн салбар - 46 а, хайрцаг - 6

Улаанбаатар, Монгол улс

Утас: 354610;354611;354618

Факс: (976-11) 354610

E-mail: muis_sfs@yahoo.com

Editorial Address:

School of Foreign Service

National University of Mongolia

P.O.-46 a, Box-6

Ulaanbaatar, Mongolia

Tel:354610; 354611;354618

Fax: (976-11) 354610

E-mail: muis_sfs@yahoo.com

ISBN 978-99962-3-202-2

ГАРЧИГ

I. Монгол улсын гадаад бодлого, олон улсын харилцаа, түүх

Зүүн (Хойд) Азийн орнуудын улс төрийн харилцаанд нөлөөлж буй соёл иргэншлийн хүчин зүйлс.....	5
<i>Г.Баасанхүү</i>	
Цөмийн аюулаас сэрэмжилсэн санал санаачлагууд, тэдгээрийн хэрэгжилт.....	10
<i>С.Баясгалан</i>	
Зөвлөлтийн дипломат алба (1917-1991).....	22
<i>Д.Доржханд</i>	
Даяаршил улс орнуудын бүрэн эрхийг хөндөж буйг олон улсын харилцааны онолд тусгасан нь	27
<i>Т.Төмөрхүлэг</i>	
Монгол улс дахь Хаант Оросын ашиг сонирхол (XX зууны эхэн үе).....	33
<i>Г.Цэнджав</i>	
Монгол, англи хоёр хэлний орчуулгын чанар, түвшний зарим асуудалд: Монгол улсын Гадаад бодлогын үзэл баримтлал (1994)-ын жишээн дээр)	45
<i>Б.Энхбаяр</i>	

II. Олон улсын эдийн засгийн харилцаа

Энэтхэг улсын нүүрсний зах зээл	51
<i>В. Энхболд</i>	
Олон улсын аюулгүй байдал, хамтын ажиллагаа газрын тосны нөөцтэй холбогдох нь.....	58
<i>С.Энхцэцэг</i>	

III. Олон улсын эрх зүй

Эртний Дорно дахины улсуудад хэрэглэж байсан цаазаар авах ялын зарим уламжлал	78
<i>Б.Амарбаясгалан</i>	
Усны салбар дахь олон улсын хамтын ажиллагаа, гэрээ конвенциуд	86
<i>Д.Бадамцэцэг</i>	
Олон улсын эрх зүйн түүх	91
<i>Ж.Баттогтох</i>	

IV. "Монгол-Данийн харилцаа: түүхэн уламжлал, орчин үе, ирээдүй" онол практикийн бага хурал

Монгол, Данийн иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагаа, үр дүн.....	112
<i>Н.Булган</i>	
Ардчилал, сайн засаглал (Данийн туршлага, Монголын тулгамдсан асуудлууд, хамтран ажиллах боломж)	115
<i>Д. Даваасамбуу</i>	
Danish-Mongolian Society	121
<i>Jan Koed</i>	

Данийн эдийн засгийн хөгжлийн туршлага, Монголд хэрэгжүүлэх боломж124
Д.Отгончимэг

Монгол-Данийн харилцаа: хоёр орны хооронд дипломат харилцаа тогтож хөгжсөн нь128
Б.Санжмятав

Монгол-Данийн их, дээд сургуулиудын хоорондын хамтын
ажиллагааг хөгжүүлэх асуудалд.....134
Д.Тунгалаг

Монгол, Данийн иргэдийн ардын дипломат харилцааны түүхээс138
Н.Тунгалаг

Ү. Хэл, соёл

Хятадын уламжлалт баярууд143
А.Батцэцэг

Орчуулах чадвар эзэмшүүлэх тухайд147
Б. Батчимэг

Өвөрмөц хэлц хэллэг хэл орон судлалын илэрхийлэл болох нь151
Б. Боргилмаа

Монгол улс болоод ХБНГУ-ын хамтын ажиллагаа, соёл боловсролын
салбарын зарим нэгэн жишээгээр157
Г. Гэрэлмаа

ЗҮҮН (ХОЙД) АЗИЙН ОРНУУДЫН УЛС ТӨРИЙН ХАРИЛЦААНД НӨЛӨӨЛЖ БУЙ СОЁЛ ИРГЭНШЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛС

Г.Баасанхүү¹

Хүйтэн дайн дуусгавар болсоор даруй 20 гаран жилийг үдээд байгаа ч энэхүү хоёр туйлт системээс үлдэж хоцорсон олон асуудлууд Зүүн Хойт Ази (ЗХА) хэмээх хямралт дэд бүс нутгийн нэг онцлог мөн. Хэдийгээр Зүүн Азийн ард түмэн түүхэн соёлын уламжлалаараа Алс Дорнодын соёл иргэншилд харьяалагддаг боловч өнгөрөгч зуунд туулсан улс төр-түүхэн замналаасаа шалтгаалан ил далд олон тооны улс төрийн зөрчилтэй байсаар ирлээ. Гэвч энэ нь бүс нутгийн дотоод гэхээсээ гадаад хүчин зүйлсээр шалтгаалагдаж байгааг үгүйсгэхгүй. Өнөөдөр соёл иргэншлийн олон нийтлэгүүд бүхий ЗХА-ийн улс гүрнүүдийн улс төр-эдийн засгийн харилцаанд интеграцчиллын үйл явц гарахгүй байгаа гол шалтгаан нь олон талаар дотоод гэхээс илүүтэй бүс нутгийн хувьд гадаад орчноос бүс нутгийн харилцаанд шууд оролцогч АНУ-ын явуулж буй гадаад бодлого, стратегитай холбоотой юм.

Хүйтэн дайн дуусгавар болсноор АНУ олон улсын харилцаанд жанжлах сонирхлын хүрээнд өөрийн өрнөдийн соёл иргэншлийн үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэхээр идэвхтэй эрмэлзэж эхэлсэн бөгөөд үүний оргил нь Ж.Бушийн Ирак, Афганистанд хийсэн дайнууд хийгээд ЗХА дахь Умард Солонгосын талаар баримталж ирсэн тус улсын эрс хатуу байр суурь ажгуу.

Сүүлийн жилүүдэд, ялангуяа АНУ-ын Ойрхи Дорнодод Ардчиллын үнэт зүйлсийг тунхаглахаар явуулсан дайн, 2008 оноос хойш үечлэн хямарсаар өнөөдрийг хүрээд байгаа Өрнөдийн орнуудын санхүү эдийн засгийн хямралаас хойш ардчилал либерализмын талаарх дэлхийн улс орнуудын байр суурь хандлага өөрчлөгдөж эхэлсэн гэж болно².

Хэдийгээр даяаршлын нөлөөгөөр хувь хүний сэтгэлгээн дэх бид нар ба би хэмээх үнэлэмжинд өөрчлөлт гарч “монгол хүн”-тэй зэрэгцэн “дэлхийн иргэн” хэмээх ухамсар идэвхтэй төлөвшиж байгаа ч энэ нь зөвхөн Америкийн соёл, өрнөдийн үнэт зүйлсийг дээдэлж байгаа гэсэн үг биш билээ.

Сүүлийн жилүүдэд, тухайлбал, XXI зууны эхний арван жилд өрнийн соёл иргэншил өмнөх эдийн засаг, цэрэг стратегийн давуу байдлаа алдаж эхлээд байна гэж болно. Үүнийг харьцуулан харж болох юм. С.Хантингтоны тэмдэглэснээр Өрнийн газар нутгийн тэлэлт 1920 онд оргилдоо хүрсэн бөгөөд тухайн үед Өрнөдийн ертөнцийн засгийн газрууд дэлхийн

¹ МУИС-ийн ОУХС-ийн багш

² *A Democratic Hegemon? The age of American hegemony// Bruce Russett. Hegemony and Democracy, NY2011., p.2*

хуурай газрын бараг тал хувийг буюу 25,5 сая кв миль хянаж байсан бол 1993 он гэхэд тэдгээрийн хянаж байсан газар нутгийн хэмжээ хоёр дахин хорогдож 12,7 сая кв.миль болсон.

Хоёрт, 1900 оны байдлаар Өрнийн иргэд дэлхийн нийт хүн амын 30%-ийг бүрдүүлж байсан бол барууны засгийн газрууд хүн амын 45%-ийг удирдаж, 1993 он болоход зөвхөн Өрнөдийн иргэдээ л удирдах болсон. Гуравт, дэлхийн валютын үйлдвэрлэл дэх Өрнөдийн эзлэх жин 1928 онд оргилдоо хүрч дэлхийн нийт үйлдвэрлэлийн 84,2%-ийг бүрдүүлж байсан бол 1950 онд 64%, 1980 онд 49% болж унасан.³ Харин 2013 он гэхэд 30% байна гэсэн судалгаа ч бий. Өөрөөр хэлбэл, хөгжлийн хурд Өрнөөс Дорно руу шилжиж байгаа явц тод харагдаж байгаа юм. Эдүгээ хүн төрөлхтний эдийн засгийн байгуулалт дахь өрний соёл иргэншлийн орыг Зүүн Ази эзлэхээр эрмэлзэж байна. Хятад гадаад худалдааны хэмжээгээр 2030 онд Америкийг тэргүүлнэ гэж "PricewaterhouseCoopers"-ийн шинжээчид үзэж байгаа⁴. Одоогоор Хятадын гадаад худалдааны ашиг 2.21 их наяд ам.доллар байгаа нь АНУ-ын гадаад худалдааны ашигт (2.66 их наяд ам.доллар) дөхөж байгаа юм. Хятад эдийн засгийн өсөлтөөр Японыг ардаа орхиж, дэлхийн хоёр дахь том эдийн засагтай улс болохоо баталсан⁵. Дэлхийн худалдааны эргэлтэд маш том өөрчлөлт гарахад ойрхон байна гэж ажиглагчид үзэж байгаа нь Хятад, Энэтхэг зэрэг орнууд эдийн засгийн өсөлтөөрөө дэлхийд тэргүүлэх хандлага гарч байгаатай холбоотой.

Дэлхийн банкны тооцож буйгаар Хятадын эдийн засгийн өсөлт энэ эрчээр үргэлжилбэл 2030 он гэхэд АНУ-ыг ардаа орхих төлөв харагдаж байгаа. Хятадын эдийн засгийн жилийн өсөлт дунджаар найман хувьтай байгаа бөгөөд 20 жилийн дараа хоёр дахин нэмэгдэнэ гэж эдийн засагчид таамаглаж байна. Дэлхийн бараа үйлдвэрлэлийн дийлэнх хувийг Хятад эзэлж байгаа нь эдийн засаг нь хүчирхэг байх нэг үндэс аж. Тус улсын хөдөлмөрийн зах зээлийн асар их нөөц үйлдвэрлэлийн өртгийг нэмэгдүүлэхгүйгээр бусад орнуудтай өрсөлдөх боломжийг олгодог билээ. Эдүгээ Хятад дэлхийн бараа үйлдвэрлэлийн 19.8 хувийг дангаараа гаргаж байна.”⁶ Зөвхөн Хятадаас гадна хэвийн бус их гүрэн хэмээн тодорхойлогддог Япон дэлхийн эдийн засагт хүчирхэг тэргүүлэгчдийн нэг хэвээр байна (Хятадын дараа 3т). Үүн дээр ЗХА-ийн чухал оролцогч, “Их 20”-ийн гишүүн Өмнөд Солонгосыг хамтатган авч үзвэл дэлхийн эдийн засаг дахь Зүүн Азийн улсуудын байр суурь хүчтэй байгаа юм. Энэ нь тус дэд бүс нутгийн зарим улсыг Өрнөдийн урд алхахад эергээр нөлөөлж байна.

Өнөөдөр соёл иргэншил судлаачдаас гадна олон улсын харилцааны онолчдын олонх нь хүлээн зөвшөөрч шүүмжлэлтэй хандаж байгаа гол асуудал бол Өрнөдийн соёл иргэншил нь шинэчлэл, ардчиллын сонгодог цор ганц загвар мөн эсэх асуудал мөн. Өрнөдийн соёл иргэншлийг тээгчдийн гол асуудал нь “Өрнөд өөрийн ертөнцийг үзэх үзлийг бусад ард түмэнд тулган хүлээлгэх эрхтэй” гэж үзэж байгаа явдал мөн. Өөрөөр хэлбэл, хэнийг шүтэж, гэр бүлийн харилцаагаа хэрхэн цогцлоож, хэрхэн зөв амьдарч, ууж идэж, хувцаслахыг заана гэсэн үг юм. Мэдээж энэ бүгд нь өрнийн бус соёл иргэншилтэй ард түмнүүдийн улс

³ Samuel P.Huntington. *The Clash of Civilizations and the Remaking of World Order*.NY,2003,p.84

⁴ *Macroeconomic news*. <http://www.ereport.ru/en/news.php>

⁵ www.IMF.report.quartall

⁶ *Хятад 2030 онд эдийн засгаар тэргүүлнэ* <http://economy.news.mn/content/59982.shtml>

төрийн бодлогод, тэр дундаа гадаад бодлогоор дамжин ширүүн эсэргүүцэлтэй тулгарсаар ирсэн. Үнэндээ АНУ-ын ерөнхийлөгчид ардчилсан үнэт зүйлсийн тухай ярихдаа зөвхөн Америкийн үнэт зүйлсийг энэ ухагдахуунд хамруулан ойлгож ирсэн. Магадгүй хувьсгалыг экспортлож, шаардлагатай үед цэргийн хүчээр өөрийн соёл иргэншлийн нөлөөндөө шахан оруулж, бүгдийг бүхнийг өөрийн загвараар байлгахыг эрмэлзэж ирсэн нь Өрнийн иргэншилтэй Америкийн гадаад бодлого амжилтгүйтэхэд хүрсэн нэг том шалтгаан мөн.

Сүүлийн жилүүдэд өрнийн судлаачид улам бүр олон улсын улс төрийн үйл явц дахь улс төрийн шинэчлэл, ардчилалд шилжих явцыг зөвхөн өрнөд загварт тулгуурлан харахаас гадна бүс нутгийн онцлог, тэдгээрийн олонлог байдлыг харгалзан үзэж авч үзэх нь зүйтэй гэж нотлож байна.⁷ Өрнийн улс төр судлаач Л.Пай өрнийн бус улс төрийн үйл явцын онцлогийг судлан тогтоож, зүй тогтлыг нь гаргахыг оролдсон бөгөөд тэрбээр өрнийн ба дорнын соёл ирнэшлийн хүчин зүйлс хэрхэн тэдгээрийн улс төрийн үйл явцад нөлөөлж ирснийг харьцуулан авч үзсэн нь сонирхолтой. Түүний судалгаагаар Дорнын соёл иргэншил дэх улс төрийн соёл нь эргээд энэхүү иргэншлийн ареалд багтаж байгаа улсуудын улс төрийн байгуулал, улс төрийн үйл явцад нөлөөлж байна.

Бидний судалгаагаар дорно ба өрнийн соёл иргэншлийн гол ялгаа нь сэтгэлгээгээр буюу хувь хүн, орон зай, цаг хугацаанд хандах хандлагаар илэрдэг.

1. Хувь хүнд хандах хандлагаар

Өрнийх: хувь хүнд ханддаг тул хүний эрх, эрх чөлөө, ардчилсан үнэт зүйлс, хувийн өмчийг дээдлэх үзэл хандлага төлөвшсөн

Дорных: хувь хүн бус, нийгэм, гэр бүлд ханддаг. Хувь хүний эрхээс илүү бусад нийгмийн гишүүдийнхээ өмнө хүлээсэн үүргийг дээдэлж, нийтийн өмч, төрийн, гэр бүлийн эрх ашгийг дээдлэх үзэл төлөвшсөн. Хувь хүн нийгэмд төрж нийгэмд төлөвшиж нийгэм дотроо өсч хөгждөг

2. Цаг хугацааны хувьд

Өрнийн хувь хүн цаг хугацааг шулуун туулсан загвараар төсөөлдөг. Ийм учраас цаг хугацаа нэг цэгээс эхлэн ямар нэг зүйлд жишээ нь хөгжил тийш явж байдаг. Харин дорныхны хувьд цаг хугацаа тойргоор хөдөлдөг. Хөгжил шаталсан хэлбэрээр явдаг буюу циклд нэг зүйл нөгөөгөөс урган гарах учир шалтгаанаар өрнөдөг.

3 Орон зайн хувьд

Өрнөдийнхний хувьд орон зай хэмээх ухагдахуун нь харилцан холбоотой хязгаарлагдмал байдаг. Жишээ нь европчуудын хувьд хил гэдэг нь хязгаар юм. Харин дорны хувьд орон зай хязгааргүйгээр төсөөлөгддөг. Тэдэнд хилийн тухай ойлголт өрнөд шиг хөгжөөгүй.⁸ Зөвхөн эндээс харахад сэтгэлгээний ийм гүн гүнзгий ялгаа нь улс төрийн үйл явц дахь шинэчлэл ба ардчилах явцыг дан ганц өрнөд, тухайлбал Америкийн ардчилсан либерал үнэт зүйлст тулгуурлан тайлбарлах боломжгүйг харуулж байна.

Түүхээс харахад өрнийн соёл иргэншлийн довтолгоон бүрд дорно өөрийнхөөрөө хариулсаар ирсэн бөгөөд үүнд бидний санахад 3 загвар байна.

⁷ *Democracy, hegemony and collective action // Bruce Russett, Hegemony and Democracy. NY2011, p.223*

⁸ *Г.Баасанхүү. Олон улсын харилцаанд дахь соёл иргэншлийн асуудалд. // "Олон улсын харилцаа". 2004 №2. 54-55*

1. Дайран орох буюу япон загвар. Шинто шашнаар гадны харийн бүхнийг үгүйсгэх аргагүй бөгөөд ариун бусыг ариусган өөртөө хэрэгтэй бүхнийг авч болно гэж үздэг япончууд өөрийн үндэс соёлын үнэт зүйлс онцлогоо хадгалангаа маш хурдтай шинэчлэгдэн өрнөдийн хөгжилтэй япон зүрх сэтгэлтэй үндэстэн хэвээр үлдсэн.
2. Кемализм буюу Туркийн дэвшлийн загвар. Баруунжина, соёлжино, боловсрон шинэчлэгдэнэ. Өрнийн загвараар өөрийн уламжлалт үнэт зүйлсээ өөрчлөх, даван туулах зорилготой. Гэвч энэ нь дотооддоо ихээхэн эсэргүүцлийг дагуулж мөн бодит үр дүн нь харагдахгүй байгааг өнөөдрийг хүртэл ЕХ-д гишүүнчилж чадаагүй Туркийн нөхцөл байдал нотлох мэт.
3. Өөрийн замаар шинэчлэгдэх буюу Ираны загвар. Өөрийн үнэт зүйлс онцлогийг хадгалах, түүндээ өөрийн онцлог бүхий шинэчлэлийг хийх. Хэдийн өрнийн зүгээс, ялангуяа АНУ-ын зүгээс хатуу ширүүн хориглолтонд орсоор ирсэн ч Иран нь өрнийн гэсэн бүхнээс 1978 оны Хомейнигийн хувьсгалаар татгалзаж өөрсдийнхөөрөө явахыг илүүд үзсэн.

Өөрөөр хэлбэл, түүхэн явцад өрнийн үнэт зүйлсийг шууд эсэргүүцэх, эс бөгөөс шууд хуулбарлахаас илүүтэй өөрийн онцлогтой хөрсөндөө буулгасан дорны ард түмэн илүүтэй хөгжиж байна гэхэд болно.

Хэдийгээр У.Черчиллийн хэлснээр ардчилал хамгийн сайн засаглалын хэлбэр биш ч бусдаас хавьгүй илүү нь үнэн юм. Гэвч дэлхий дээр өрнөдийн болон өрнийн бус нийгмийн олон хэлбэрүүд оршсоор байгаа бөгөөд тэдэн дунд Зүүн Азийн гэсэн онцлог дэд хэлбэр бий. Түүхээс харахад Зүүн Азид ч гэсэн ардчиллын өөрсдийн онцлог илэрч байдаг. Жишээ нь, Японы, Вьетнамын, Тайваний гэх мэт. Эдгээр улсын нийгмийн ардчилал нь Америк, Европынхоос эрс ялгаатай ч ардчилал мөн юм.

Зүүн Ази дахь Өмнөд Солонгос, Япон, Монголын нийгмүүд нь өөр өөрийн соёл, нийгэм сэтгэхүйн онцлог, үндэсний сэтгэлгээ, үндэстний шинж чанараараа ялгардаг ч ардчилсан либерал үнэт зүйлсийг дээдэлсэн улс төрийн тогтолцоотой билээ.

Харин эргээд соёл иргэншлийн хүчин зүйл нь Зүүн Азийн орнуудын улс төрийн харилцаанд хэрхэн нөлөөлж байна вэ. Бидний санахад

1. ЗХА-д интеграцчлах үйл явц эрчимжих үү хэмээх асуудалд эргэлзээтэй гэж хэлэх байна. Дээр дурдсанчлан дорнын сэтгэлгээнд хувь хүнээс илүү нийгэм чухал байдаг. Ийм ч учраас нийгмийнхээ, тухайлбал, гэр бүл, төрт улс, үндэстнийхээ үнэт зүйлсийг дээдлэгч ард түмнүүд нь харийн буюу өөр нийгмийн бүлэгтэй нэгдэх асуудалд хойрго буюу татгалзсан хандлагатай байдаг. Энэ нь ЗХА-ийн улсуудыг үндэстнийхээ эрх ашгаас илүүтэй бусдын эрх ашгийг дээдэлсэн байр суурьт шилжих боломжийг багасгаж байгаа юм. Өөрөөр хэлбэл, интеграцчлагдах үйл явц удаашралтай гэсэн үг болно.
2. ЗХА дахь улс төрийн хямралт байдал эцэслэн зохицуулагдах уу хэмээх асуудалд мөн л явц удаашралтай хэмээн хариулах байна. Зарим судлаачдын тодорхойлсноор ЗХА-ийн дэд бүс нутаг дахь улс төрийн асуудлууд нь “унтаа” түвшинд байгаа хямралууд юм. Өөрөөр хэлбэл, хэсэг идэвхжээд зохицуулагдавч үндсэндээ голомт нь зохицуулагдахгүй үлдэж байдаг. Энэ нь мөн л дээрх сэтгэлгээний онцлогоос

хамаарч байгаа бөгөөд нийгмийнхээ буюу үндэстнийхээ эрх ашгийн төлөө дурын эрхээс татгалзах чадвартай төдийгүй дурын өрсөлдөгчид бууж өгөх сонирхолгүй байдаг. Нөгөөгүүр эдгээр хямралыг хүчээр зохицуулах магадлал сэтгэлгээний онцлогоос хамааран эрс бага байгаа юм. Учир нь дэлхийн бусад улстай харьцуулахад нэг этнос бүхий үндэстэнтэй, шашин сэтгэхүйн уламжлалаараа шууд хүч хэрэглэхээс татгалздаг онцлог ЗХА-ийн нэг онцлог юм.

3. Хятад их гүрэн болох уу, тэр дэлхийн их гүрэн болох сонирхолтой юу? Өрнийн соёл иргэншил бүхэлдээ хувь хүнд хандсан байдгаас “би” гэсэн сэтгэлгээ өрнийн онцлог болж байдаг. Ийм ч учраас хувь хүн төвтэй сэтгэлгээний онцлог бүхий өрнийн их гүрнүүд өөрийн үнэт зүйлсийг бусдад тулгах, бүх дэлхийг хуваан захирахыг эрмэлзэх, ямар ч үнээр хамаагүй өөрийн зорилгоо гүйцэлдүүлэхийг эрмэлзэж байдаг. Энэ нь Британий эзэнт гүрэн болон өнөөгийн АНУ зэрэг өрнийн их гүрнүүд түүхэн хүчирхэгжсэн үе бүрдээ нэр алдрын төлөө бодлого явуулж улмаар дэлхийд дангаар ноёрхох (жанжлахыг)-ыг эрмэлзэхэд хүргэсэн. Харин дорнын, тэр дундаа хятад ухаанаар бол тэд бүх нөөцөө шавхан 100 жил дэлхийн эзэн сууснаас 1000 жил өөрийн дураар өөрийн орон зайдаа хаан суухыг эрмэлзэнэ. Энэ нь Хятад дэлхийн их гүрэн болсон ч дангаар жанжлахыг эрмэлзэхгүй гэсэн дүгнэлт хийхэд хүргэж байна. Өөрөөр хэлбэл, күнзийн сэтгэлгээний онцлогоор Хятад олон туйлт олон улсын харилцааны дэг журмыг чухалчлаж байгаа нь үнэн болов уу.

Энэ мэтээр олон улсын улс төрийн харилцааг улс төр, эдийн засгийн үүднээс бус соёл иргэншил, сэтгэлгээний хэв шинжээр нь харьцуулан судалж үзвэл зарим нэг сонирхолтой санал гарч болзошгүй юм.

Зүүн Азийн олон улсын улс төрийн харилцаанд соёл иргэншлийн хүчин зүйл эергээр нөлөөлдөг бөгөөд энэ нь олон тооны хямралууд соёл иргэншлийн нөлөөгөөр дүрэлзэн мөргөлдөөнд хүрдэггүй зэрэг байдлаар илэрч байна.

Монгол улс өнөөдрийн зарим илтгэгчдийн тодотгож байгаачлан биеэ даасан нүүдлийн соёлтой боловч тэнгэр шүтлэг, төрөө, гэр бүлээ дээдлэх үзэл, ахас ихсийг хүндэтгэх ёсон, бүлээр хөдөлмөрлөх, арга билгийн ухаан, бурхны шашны махаяна урсгалыг шашин нийгэмд зонхилдог зэрэг олон нийтлэгээр ЗХА-ийн ард түмнүүдийн буюу Алс Дорнодын соёл иргэншилд хамрагдах нийтлэг үндэслэл бий гэж хувьдаа үздэг.⁹ Энэ нь бүсийн улсуудтай хоёр талын болон олон талт улс төрийн болон бусад харилцааг гүнзгийрүүлэн идэвхтэй хөгжүүлэх том хүчин зүйл болж байгаа билээ.

⁹ Г.Баасанхүү. ЗХА-ийн ард түмнүүдийн соёл иргэншилд Монголын хамрагдах нийтлэг үндэслэл.// “ЗХА-ийн төлөв, байдал ба Монгол улс”. УБ.2003,275-287-р тал